



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дах хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, тайланг 2023 оны 2 дугаар сарын 1-ний дотор Авлигатай тэмцэх газар хүргүүлэхийг Тамгын газар /Б.Батсүх/-т даалгасугай.


3. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн тооцоог хянаж, жил бүр төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлж байхыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар /Ц.Ганцэцэг/-т үүрэг болгосугай.



ДАРГА

Д.ЗОРИГТ


Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2022 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн
А/А... дугаар тушаалын хавсралт




Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газраас
2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага			Хөрөнгийн хэмжээ эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
				Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Бусад оролцогч байгууллага		
1	Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх	Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод нийгмийн даатгалын талаарх мэдээлэл, зөвлөгөөг шуурхай хүргэх зорилгоор ажиллуулж буй “Нийгмийн даатгалын мэдээлэл зөвлөгөө” facebook хуудсуудыг сайжруулах, үйл ажиллагааг тогтмолжуулах	Жилийн турш	НДЕГ	Аймаг дүүргийн НДХ-ийн ажилтнууд	-	- Төсөв шаардлагагүй	Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод нийгмийн даатгалын талаарх мэдээлэл, зөвлөгөөг шуурхай хүргэх үйл ажиллагааг тогтмолжуулж ажилласан байна.
		ISO 9001:2015 олон улсын стандартад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;	Жилийн турш	НДЕГ	ТГ, СОНХАГ	-	Дэлхийн банкны төслийн санхүүжилтээр	Жилийн эцэст Нийгмийн даатгалын ерөнхий газар, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Увс аймаг, Багануур, Баянгол, Налайх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй, дүүргийн нийгмийн


							даатгалын хэлтсүүдийн үйл ажиллагаанд ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлсэн байна.	
		Ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх;	Жилийн турш	НДЕГ	СОНХАГ	Аймаг, дүүргийн НДХ-үүд	20 сая	Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх, зорилтот сургалт, арга хэмжээг зохион байгуулсан байна.
		Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ач холбогдол, үйл ажиллагаа, үйлчилгээг иргэдэд ойлгомжтой, шинэлэг байдлаар тайлбарласан контент бэлтгэх; /Видео,постер.../	Жилийн турш	НДЕГ	СОНХАГ	Аймаг, дүүргийн НДХ-үүд	-	Шинэ контентийн агуулга, хэлбэрийг тодорхойлон бэлтгэж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон сошиал сүлжээгээр нэвтрүүлэн иргэд (даатгуулагч), ажил олгогчид хүргэсэн байна.
2	Өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх,	Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төв, Нийгмийн даатгалын мэдээллийн лавлах 77771289 утасны үйл ажиллагааг өргөжүүлэх, байгууллагын цахим хуудас, FB хуудсанд ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэлд цахим хэлбэрээр хариу өгөх, шийдвэрлэхэд	Жилийн турш	НДЕГ	ТГ, ҮАХХ	-		Цахим үйлчилгээ сайжирсан байна




	хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх	хяналт тавих						
3	Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох	Хяналт шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор хийнэ	Жилийн турш	НДЕГ	ДАМГ ХШГ	Аймаг, дүүргийн НДХ-үүд	Төсөв шаардлагагүй	Нийгмийн даатгалын үйлчилгээнд хяналт тавина
		Нийгмийн даатгалын тухай хуулиуд, Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, батлагдсан удирдамжийн дагуу аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, ажил үйлчилгээний үр дүнг тооцож ажиллах;	Жилийн турш	НДЕГ	ДАМГ ХШГ	Аймаг, дүүргийн НДХ-үүд	Төсөв шаардлагагүй	Нийгмийн даатгалын тухай хуулиуд, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг батлагдсан удирдамжийн дагуу дурдсан аймаг, дүүргүүдийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн ажил үйлчилгээний үр дүнг тооцсон байна.



4	Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд мэдээллийн шинэчилсэн системийг турших, нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэх;	Жилийн турш	НДЕГ-МТТ	БХСГ	Аймаг, дүүргийн НДХ-үүд	Төсөв шаардлагагүй	-Нийгмийн даатгалын салбарын бүх байгууллагуудад мэдээллийн шинэчилсэн системийг нэвтрүүлсэн байна. -Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг бодит цагийн горимоор үзүүлнэ.
		Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, төрийн мэдээллийн нэгдсэн сангаас нийгмийн даатгалын үйлчилгээг тогтвортой үзүүлэх;	Жилийн турш	НДЕГ-МТТ			Төсөв шаардлагагүй	-Иргэд даатгуулагч, ажил олгогч, харилцагч байгууллагуудад “Нийгмийн даатгал” аппликейшн, “Даатгуулагчид зориулсан вэб”, ТҮЦ машин, төрийн цахим үйлчилгээний e-mongolia нэгдсэн порталаар дамжуулан цахимаар үзүүлэх мэдээллийн үйлчилгээг өргөжүүлж, тогтвортой ажиллагааг хангасан байна. -Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан төрийн байгууллагатай



								мэдээлэл солилцох үйлчилгээг өргөжүүлж, тогтвортой ажиллагааг хангасан байна.
		Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тогтоолгох өргөдөл, материалыг даатгуулагчаас цахимаар хүлээн авч, шийдвэрлэх ажлыг эхлүүлэх;	Жилийн турш	НДЕГ	БХСГ МТТ	Аймаг, дүүргийн НДХ-үүд	Төсөв шаардлагагүй	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд шинээр нэвтрүүлэх цогц системийг ашиглан даатгуулагч тэтгэвэр тогтоолгох хүсэлт, холбогдох баримт материалаа нийгмийн даатгалын байгууллагад цахимаар илгээх боломжийг бүрдүүлсэн байна.
		Даатгуулагчдад ажилгүйдлийн тэтгэмж олгох үйлчилгээг цахимаар хүргэх	Жилийн турш	НДЕГ	БХСГ МТТ	Аймаг, дүүргийн НДХ-үүд	Төсөв шаардлагагүй	-Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ цахимаар илгээх боломжийг бүрдүүлсэн байна. - Ажилгүйдлийн тэтгэмж олголтын үйлчилгээг зайнаас үзүүлэх нөхцөл хангагдсан байна.



5	Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх	Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх;	Жилийн турш	НДЕГ	СОНХАГ	Аймаг, дүүргийн НДХ-үүд	Төсөв шаардлагагүй	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх цахим болон танхимын сургалтуудыг зохион байгуулсан байна.
		Шатлан дэвших журмыг хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах, сул орон тоонд төрийн албан хаагчдыг хууль, журмын дагуу томилох ажлыг хэрэгжүүлэх	Жилийн турш	НДЕГ	ТГ	Аймаг, дүүргийн НДХ-үүд	Төсөв шаардлагагүй	Холбогдох ажилтнууд сургалтад хамрагдсан байна.
		Авлигын эсрэг сургалт сурталчилгаа зохион байгуулах	Жилийн турш	НДЕГ	ТГ, СОНХАГ, хэлтсүүд	АТГ	Төсөв шаардлагагүй	Албан хаагчдын 80 орчим хувийг хамруулсан байх
		Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг(ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох	Жилийн эцэст	НДЕГ	МТТ	АТГ	Төсөв шаардлагагүй	Дүгнэлтийг нээлттэй, ил тод болгох ажил хэвшсэн байх

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

